

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС


ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдааны 17 дугаар тэмдэглэлд:

“ХҮ.1. Сангийн сайд Ч.Хүрэлбаатар улсын төсвийн хөрөнгөөр 2018 онд худалдан авах ажиллагааны төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн I улирлын дүнг захиалагч нэг бүрээр нь Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:

1. яамд хариуцан хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай зохион байгуулж, мөн аймаг, нийслэлд шилжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт тавьж, эрчимжүүлж ажиллахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгав.

2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас хариуцан хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний зураг төсөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дутууг энэ оны 4 дүгээр сарын 25-ны дотор тус газарт хүргүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа, Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат нарт даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР